



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2007 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 19

Хашаат

Сумын сүлд дуу батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62.2, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22.1.4-р заалтуудыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Ж.Адъяагийн шүлэг, Д.Цэцэрлэгийн хөгжим “Алдартны нутаг Дэлгэрхангай” дууг сумын сүлд дуу болгон өргөмжилсүгэй.

Хоёр. Сумын сүлд “Алдартны нутаг Дэлгэрхангай” дууг эгшиглүүлж байх журмыг хавсралтаар баталсугай.

Гурав. Сумын сүлд дууг сүслэн дээдэлж иргэдэд сурталчилан алдаршуулж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга Б.Түвшинбаярт даалгасугай.



ИТХ-ЫН ДАРГА

Т.МЯГМАРСҮРЭН



Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2007 оны 08 сарын  
29 ны өдрийн 19 тоот тогтоолын хавсралт

**СУМЫН СҮЛД "АЛДАРТНЫ НУТАГ ДЭЛГЭРХАНГАЙ" ДУУГ  
ЭГШИГЛҮҮЛЭХ, ХҮНДЭТГЭХ ТУХАЙ**

**Нэг. Сумын сүлд дууг эгшиглүүлэх**

А. Сүлд дууг дараах тохиолдолд эгшиглүүлнэ.

1. Сум болон бүс нутгийн чанартай томоохон хурал зөвөлгөөн
2. Орон нутгийн хэмжээний түүхэн тэмдэглэлт үйл явдал
3. Сум болон бүс нутгийн чанартай биеийн тамир спортын уралдаан тэмцээн наадам /урлагийн/ тэдгээртэй адилтгах арга хэмжээнд
4. Орон нутгийн телевизийн нэвтрүүлэг эхлэхэд сумын сүлд дууллыг эгшиглүүлж байна.

Б. Сүлд дууллыг дуу бичлэгийн хэрэгсэл ашиглан эгшиглүүлж болно.

В. Сүлд дууллын эхний хоёр бадгийг дээрх 4 тохиолдолд эгшиглүүлнэ.

**Хоёр. Сүлд дууллыг хүндэтгэх**

Сумын сүлд дууллыг олны өмнө эгшиглүүлэхэд босож хүндэтгэнэ.



# Дэлгэрхангай сумын Сүлд дуу

Үгийг Ж.Адъяа

Аяыг Цэцэрлэг

## “АЛДАРТНЫ НУТАГ-ДЭЛГЭРХАНГАЙ”

Өвгийн голомтыг мөнхөд бадраасан  
Өлгийн бүүвэйтэй инээд цалгилсан  
Өнөр түмний амьдрал өрнөсөн  
Өнөд түвшин жаргал гийсэн

Буурал говийн наран зулай  
Буяны тахилгатай Дэлгэрхангай  
Алтан тэвш нь дүүрэн билэгдэлтэй  
Алдартны нутаг Дэлгэрхангай минь

Нүнжиг буяныг хурайлж далласан  
Нүглийн сүүдрийг үргээж ариулсан  
Амьдын заяанд адилхан жаргаасан  
Амин холбоог ижилхэн тэгшилсэн

Буурал говийн наран зулай  
Буяны тахилгатай Дэлгэрхангай  
Алтан тэвш нь дүүрэн билэгдэлтэй  
Алдартны нутаг Дэлгэрхангай минь

Ээжийн өргөсөн цацлаар ивэлсэн  
Элбэрэл ачлалын дээдээр ивээсэн  
Ойр холоос ч сэтгэлд хоногшсон  
Очсон буцсан ч итгэл түшсэн

Буурал говийн наран зулай  
Буяны тахилгатай Дэлгэрхангай  
Алтан тэвш нь дүүрэн билэгдэлтэй  
Алдартны нутаг Дэлгэрхангай минь

Мирис М. Агбара

Агбер. А. Оросопин

Агберини ниганс Оросопини

Handwritten musical score with lyrics in a non-Latin script. The score consists of ten staves of music, each with a treble clef and a key signature of one sharp (F#). The lyrics are written below the notes.

Lyrics (from top to bottom):

Об-уиу гонери бу мон хог гог-роа-сау  
 он сии бу-би сии уиуу гонер-сау  
 он-ог муну нии ауб-пул оро-сау  
 он-ог муну нии ауб-пул нии о сии  
 буу-раа тоб нии НАР-АХ зы-к-ан  
 туга нии тапу лас сии дон-туп ХАН-ган  
 Ан-тин тоб нии уу-пул оро-сау-ган  
 Агберини-ниу ну-тар дон-туп Хан гали о милл